



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Өргөдөл, хүсэлтийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Д.Батбаатар, Г.Банзрагч, Н.Баярмаа, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Улсын дээд шүүхийн цахим бүртгэлийн санд С.Эрдэнийн нэрийг сэргээлгэхийг хүссэн Д.Эрдэнэсүвдэн өргөдлүүд, Ардчилсан намын Үндсэн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Ө.Шижирийг тус намын хуулийн этгээдийн улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэхийг хүссэн И.Мөнхжаргал нарын өргөдлүүдийг Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч Д.Батбаатар нарын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Хэрэг эрхлэх газрын дарга гэх Д.Эрдэнэсүвдаас:

- 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн ХЭГ-35 дугаар албан бичгээр "... Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд С.Эрдэнэ мөн болохыг ... баталгаажуулан, намын XIV Их хуралд уламжлан хэлэлцүүлэхээр 37 тоот тогтоол гаргасан, ... Ардчилсан намын XIV Их хурлыг 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, дээрх 37 дугаар тогтоолыг хэлэлцэн, ... батламжилж, Улсын дээд шүүхэд уламжлахаар шийдвэрлэсэн" гэж, "Улсын дээд шүүхийн цахим бүртгэлийн санд С.Эрдэнийн нэрийг сэргээлгэх талаар";
- 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн ХЭГ-40 дүгээр албан бичгээр мөн ижил агуулгатай, "Улсын дээд шүүхийн цахим бүртгэлийн санд С.Эрдэнийн нэрийг сэргээлгэх талаар";
- 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн ХЭГ/39 дүгээр албан бичгээр "Ардчилсан намын XIV Их хурлыг 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж, намын Үндэсний бодлогын хорооны гишүүд, Үндсэн дүрмийн хороо, Дотоод сонгуулийн хорооны бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн батламжилсан шийдвэрийг гаргасан ... мэдээллийг хүргүүлж байна" гэх албан бичгүүдийг тус тус;

Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргал, П.Нүрээд, Б.Ган-Очир нараас:

- 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 02/166 дугаар албан бичгээр “Ардчилсан намын Ээлжит бус Их хурал 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр хуралдан, тус намын Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт /оруулсан/, мөн... Ардчилсан намыг тодорхой хугацаанд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхийг Ө.Шижирт олгосон ... тул Үндсэн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, түүнчлэн, ... Ө.Шижирийг Ардчилсан намын хуулийн этгээдийн улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийж өгнө үү ...” гэх;
- 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 02/178 дугаар албан бичгээр “... намын Үндсэн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.10.1.1-д зааснаар намын дарга С.Эрдэнэ огцорсонд тооцогдсон. ... Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоол ...-оор бүртгэсэн дүрмийн өөрчлөлт нь огцорсонд тооцогдсон даргад буцаж үйлчлэхгүй. ... Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.12.1, 5.12.4.11 дэх заалтуудад ... зохицуулсны дагуу АН-ыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхийг тэргүүн дэд дарга /Ө.Шижир/-т олгосон” гэх агуулгатай “Нэмэлт тайлбар өгөх тухай” гэх албан бичгүүдийг тус тус Улсын дээд шүүхэд ирүүлэв.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар эдгээр өргөдөл, хүсэлт, албан бичгүүдийг нэгтгэн хэлэлцээд,

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн цахим бүртгэлийн санд С.Эрдэнийн нэрийг сэргээлгэхийг хүссэн Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Хэрэг эрхлэх газрын дарга гэх Д.Эрдэнэсүвдын хүсэлт, Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргал, П.Нүрзэд, Б.Ган-Очир нараас гаргасан Ардчилсан намын Үндсэн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх, Ө.Шижирийг Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэх хүсэлтүүдийг тус тус хангахгүй орхиж, бүртгэлд бүртгэхээс татгалзаж, өргөдлийг буцааж шийдвэрлэлээ.

Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн шүүх хуралдааны 04 дүгээр тогтоолоор “... Ардчилсан нам /АН/-ыг төлөөлөх эрхтэй этгээд, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудал маргаантай гэж үзэж Ц.Тувааныг намын даргын үүрэг гүйцэтгэгчээр цахим бүртгэлд бүртгэснийг хасаж, ... Улсын дээд шүүхийн цахим бүртгэлд С.Эрдэнийг Ардчилсан намын даргаар бүртгүүлэх хүсэлтийг хангахаас татгалзаж ... , ... Ардчилсан намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэж, бүртгэл хийлгэхээр дахин хандах эрхтэй ба харин намыг төлөөлөх эрхтэй этгээдийн бүртгэл цахим мэдээлэлд тодорхой бус үлдсэн болохыг дурдаж ...” шийдвэрлэсэн, мөн шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “... С.Эрдэнэ, Ц.Туваан нарыг намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд болохыг тогтоосон 2021 оны 01 дүгээр сарын 15, 16-ны өдрийн Үндсэн дүрмийн хорооны хуралдааны тогтоолуудыг хүчин төгөлдөр шийдвэр гэж үзэх үндэслэлгүй, улмаар Намын дарга, түүнийг төлөөлөх этгээдийн талаар нам дотооддоо шийдвэрлэх талаарх Улсын дээд шүүхийн 04 дүгээр тогтоолд заасан зөрчил арилаагүй” гэсэн дүгнэлт хийж, “Улсын дээд шүүхийн цахим бүртгэлд Ардчилсан намын даргаар бүртгэгдсэн бүртгэлийг сэргээлгэх”-ээр гаргасан С.Эрдэнийн хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн, түүнчлэн, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Улсын дээд шүүхийн 2021 оны дээр дурдсан 04, 09 дүгээр тогтоолууд хүчин төгөлдөр, түүнд дүгнэгдсэн нөхцөл байдлууд арилаагүй гэж үзэж, намын даргаар О.Цогтгэрэл, М.Тулгат нарыг

бүртгүүлэхээр ирүүлсэн хүсэлт, түүнчлэн “Улсын дээд шүүхийн цахим сан дахь С.Эрдэнийн бүртгэлийг сэргээх тухай” гаргасан хүсэлтүүдийг тус тус хангахгүй орхиж шийдвэрлэсэн, эдгээр тогтоолууд хүчин төгөлдөр байна.

Түүнчлэн, дээрх өргөдлүүдийг хэлэлцэхтэй холбогдуулан:

- Ардчилсан намын гишүүн, Үндэсний бодлогын хорооны гишүүн 14 дүгээр их хурлын төлөөлөгч гэх Д.Алтанхуягаас 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр “... С.Эрдэнэ нь өөрийгөө Ардчилсан намын дарга мөн, Улсын дээд шүүхийн бүртгэлд би Ардчилсан намын даргаар бүртгэлтэй байгаа гэж намын гишүүдийг хууран мэхэлж намын үйл ажиллагааг дүрмийн бус аргаар удирдан явуулсаар байна. ... Ардчилсан намын 14 дүгээр Их хурлаас гаргасан гэх дүрмийн бус “С.Эрдэнийг Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдээр бүртгүүлэх тухай” хүсэлтийг татгалзаж өгнө үү ...” гэх агуулгатай “Өргөдөл гаргах тухай”;

- Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын дарга гэх Д.Эрдэнэсүвдаас 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн ХЭГ/43 дугаар албан бичгээр “Ө.Шижирийг Ардчилсан намын хуулийн этгээдийн Улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэх асуудлаар Ардчилсан намын бүтцийн аль ч байгууллагаас шийдвэр огт гаргаагүй” гэж, “Ө.Шижирийг Ардчилсан намын хуулийн этгээдийн Улсын бүртгэлд бүртгүүлэхийг эс зөвшөөрөх тухай”;

- Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын дарга гэх Д.Эрдэнэсүвдаас 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ХЭГ/44 дүгээр албан бичгээр “... Ардчилсан намын зүгээс дээрх нэр бүхий этгээдүүдийг АН-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр огт томилоогүй, ... нэр бүхий хэсэг бүлэг иргэд АН-ын нэрийг барин хүчингүйд тооцож, ашиглахыг хориглосон ... тамганы дардас хэрэглэн, УДШ-д ... өргөдөл хүргүүлсэн ... уг хүсэлтийг хүлээн авахгүй байх үндэслэл болно. Ө.Шижирийг Ардчилсан намын хуулийн этгээдийн Улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгүүлэх гэсэн хууль бус үйлдлийг ... Ардчилсан нам эрс эсэргүүцэж байна” гэх агуулгатай “Шаардлага хүргүүлэх тухай”;

- Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын дарга гэх Д.Эрдэнэсүвдаас 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн ХЭГ/45 дугаар албан бичгээр “иргэн И.Мөнхжаргал гэгч өөрийгөө АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга хэмээн нэрлэж, АН хэзээ ч хуралдаагүй Их хуралдааны /2022.08.18/ шийдвэр гэх зүйлийг УДШ-д хүргүүлсэн ... АН-ыг төлөөлөн УДШ-д өргөдөл гаргах эрхгүй этгээд .../тул/ И.Мөнхжаргал, Ө.Шижир нарын гаргасан өргөдлийг хэлэлцэхээс татгалзан буцаан өгнө үү” гэх агуулгатай “Хүсэлт хүргүүлэх тухай” албан бичгүүдийг тус тус Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.17.1, 5.17.4.1-д тус тус зааснаар “Намын дарга нь Намын тэргүүн бөгөөд Ардчилсан намыг төлөөлөх эрх бүхий этгээд” байх тул тус намын дарга нь улсын бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд өөрчлөлт орсныг бүртгүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй, харин энэ тохиолдолд, дээрх баримтуудаас үзвэл Ардчилсан намын дарга буюу итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд хэн болох талаар намын доторх маргаан эцэслэгдээгүй нь шүүхийн дээр дурдсан тогтоолуудад заасан үндэслэл арилаагүй гэж үзэх үндэслэл болно.

Энэхүү үндэслэл нь мөн Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдөлд ч хамааралтай гэж үзэв.

Иймд “...Улсын дээд шүүхийн цахим бүртгэлийн санд С.Эрдэнийн нэрийг сэргээлгэх”-ээр гаргасан Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Хэрэг эрхлэх газрын дарга гэх Д.Эрдэнэсүвдын хүсэлт, “... “Ээлжит бус Их хурлаар баталсан

Үндсэн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Ардчилсан намыг тодорхой хугацаанд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх олгосон Ө.Шижирийг Ардчилсан намын хуулийн этгээдийн улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэх"-ээр гаргасан Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргал, П.Нүрзэд, Б.Ган-Очир нарын хүсэлтүүдийг бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. “Улсын дээд шүүхийн цахим бүртгэлийн санд С.Эрдэнийн нэрийг сэргээлгэх”, “Ээлжит бус Их хурлаар баталсан Үндсэн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Ардчилсан намыг тодорхой хугацаанд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх олгосон Ө.Шижирийг Ардчилсан намын хуулийн этгээдийн улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэх” тухай өргөдлүүдийг буцааж, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2. Хүсэлт гаргагч И.Мөнхжаргал, П.Нүрзэд, Б.Ган-Очир нараас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 300,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ШҮҮГЧИД

Д.МӨНХТУЯА

Д.БАТБААТАР